

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын  
эрх зүйн байдлын тухай хуулийн  
шинэчилсэн найруулгын төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”, 2021 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 20-ны өдөр баталсан Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан.

Монгол Улсын Их Хурлаас 1994 оны 07 дугаар сарын 05-ны өдөр баталсан Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль нь нийслэлийн нийгэм, эдийн засгийн асуудлыг 27 жилийн хугацаанд зохицуулж байгаа бөгөөд нэг удаа уг хуульд өөрчлөлт орсон байна.

Монгол Улсын нийслэлийн чиг үүргийг гүйцэтгэж байгаа онцлог нэгж болох Улаанбаатар хотод үйлчлэх нийт 150 гаруй хууль тогтоомж нь өөр хоорондоо уялдаа муутай, зарим зохицуулалт нь давхардсан, нийслэл хотын онцлог, цаашдын хөгжлийн загвар, улс орны хөгжилд гүйцэтгэх үүрэг, төрийн бусад байгууллагатай харилцах зэрэг асуудлаар бусад орны жишгийг судалж, нэвтрүүлэх талаар олон судалгаа, практик ажилтнуудын санал зөвлөмж гарсаар байна.

Ийнхүү Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт болон Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэх, дээр дурдсан бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны санал, зөвлөмжид үндэслэн нийслэл хот нийгэм, эдийн засгийн хувьд бие даан хөгжих хөшүүргийг бий болгох, хүн амын төвлөрлийг сааруулах, нийслэлийг нэг төвт хотоос олон төвт, орчин үеийн хот болгон хөгжүүлэх, нийслэлийн дагуул хот, тосгодыг хөгжүүлэх, нийслэлийн удирдлагын эрх зүйн байдлыг боловсронгуй болгох зорилгоор хуулийн төслийн үзэл баримтлалыг тодорхойлж, түүнд нийцүүлж Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловрууллаа.

Хуулийн төсөл нь нийт 7 бүлэг, 51 зүйлээс бүрдэх бөгөөд хуулийн төсөлд зарчмын шинжтэй дараах харилцааг зохицуулахаар тусгалаа.

Хуулийн төслийн зорилт нь нийслэл Улаанбаатар хотын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх эдийн засгийн үндэс, үйл ажиллагааны зарчим, удирдлагын эрх хэмжээ, нийслэл хотын удирдлагаас төрийн дээд, төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болон бусад этгээдтэй харилцах эрх зүйн үндсийг тодорхойлоход оршино.

**Нэгдүгээр бүлэгт** Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нийслэл хотын зохион байгуулалтын үндэс, нийслэл хотыг хөгжүүлэх бодлого, нийслэл хотын эдэлбэр газар, бүсчлэлтэй холбоотой харилцааг тусгалаа.

Нийслэл эдэлбэр газартай, эдэлбэр газар нь бүсчлэл, дүрэмтэй байх бөгөөд бүсчлэл, дүрмийг Засгийн газраас тогтоосон шалгуур үзүүлэлтийг үндэслэн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлахаар тусгав.

**Хоёрдугаар бүлэгт** нийслэл хотын чиг үүрэг, нийслэлийн дүрмийн талаар тусгалаа.

Нийслэлийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болохын хувьд Монгол Улсын засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хуульд заасан чиг үүргээс гадна нийслэл хот болохын хувьд хэрэгжүүлэх тусгай болон хотын аж ахуйн чиглэлээр хэрэгжүүлэх бусад чиг үүргийг энэхүү хуулийн төсөлд тодорхойлов.

Улаанбаатар хотын хувьд хэрэгжүүлэх тусгай чиг үүргийн хүрээнд төрийн дээд, төв байгууллага, гадаад улсын дипломат төлөөлөгчийн газар, олон улсын байгууллагын хэвийн дэд бүтцийг бүрдүүлэх, үндэсний болон олон улсын хэмжээний баяр наадам, хурал, урлаг, спортын болон бусад арга хэмжээг зохион байгуулах, олон улсын зорчигч болон ачаа тээвэр, логистикийн үйл ажиллагааг зохицуулах, нийслэл дэх үндэсний хэмжээний түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалт, нийслэлийн нутаг дэвсгэр дэх голын хамгаалалт, тохижилт, нийслэлийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх олон улсын чанартай авто зам барих, түүнийг арчлах, засварлах үйл ажиллагаа, иргэдийг нийгмийн болон инженерийн дэд бүтцээр хангах, агаар, хөрс, дуу чимээний бохирдлыг бууруулах үйл ажиллагаа зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эдгээр тусгай чиг үүргийг нийслэл нь Засгийн газрын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх бөгөөд бөгөөд үүнд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр тусгалаа. Тухайлбал, тусгай чиг үүргийн нэг болох нийслэл дэх голын хамгаалалт, тохижилтын талаарх олон улсын туршлагаас судлахад Сөүл хот Хан мөрний арчлалт, хамгаалах асуудлыг Засгийн газартайгаа хамтран хэрэгжүүлдэг бөгөөд үүнд жилд 47.9 тэрбум вонн зарцуулдаг байна.

Түүнчлэн нийслэл хот нь хотын аж ахуйн асуудлаарх тодорхой чиг үүрэг буюу нийслэлийг хөгжүүлэх сангийн менежмент, авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, нийслэл хотын хүний нөөцийн бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилт, орчны аюулгүй байдал, хүнсний хангамж, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл, хот, суурин газрыг дахин хөгжүүлэх үйл ажиллагаа, хүн амын ундны болон ахуйн хэрэглээний төвлөрсөн усан хангамж, хэсэгчилсэн инженерийн хангамж, ус, дулаан, цахилгаан хангамж, гадна болон явуулын зар сурталчилгааны зохицуулалт, хяналт зэрэг бусад чиг үүргийг бие даан хариуцан хэрэгжүүлэхээр тусгалаа.

Мөн нийслэл хот өөрийн дүрэмтэй байх бөгөөд дүрмийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурал батлахаар тусгав. Хотын дүрэмд тусгах асуудлыг хуульд тодорхой зааж өглөө. Тухайлбал, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн, авто зогсоол, автозамын арчлалт хамгаалалт, шашны, соёлын үйл ажиллагаа, аялал жуулчлалын байгууллага, зочид буудлын үйл ажилагааны бүртгэл, зэрэглэл тогтоох, мал, тэжээвэр амьтны зохицуулалт, такси, хүртгэлтийн үйлчилгээ,

нисгэгчгүй нисэх төхөөрөмж буюу дроны ашиглалт зэрэг нийслэл дэх нарийвчилсан зохицуулалт шаардлагатай үйл ажиллагааг зохицуулахаар тусгав.

Түүнчлэн дүрмийн төслийг боловсруулахдаа олон нийтийн саналыг заавал авах, баталсны дараа иргэдэд таниулах боломж олгох зорилгоор гурваас доошгүй сарын дараа дагаж мөрдөхөөр зохицууллаа.

**Гуравдугаар бүлэгт** нийслэл хотын эдийн засгийн харилцааны талаар тусгасан бөгөөд нийслэл хот нь Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон “эдийн засаг, нийгмийн цогцолбор”-ын хувьд тусгай болон хотын аж ахуйн асуудлаарх бусад чиг үүргийг хэрэгжүүлэхдээ эдийн засаг, нийгмийн асуудлаа бие даан шийдвэрлэх бодит боломжийг бүрдүүлэхийг зорилоо.

Ингэхдээ нийслэл хотын эдийн засгийн үндэс, нийслэлийн өмч, түүний харилцаа, нийслэлийн үнэт цаас гаргах, концесс олгох, нийслэл хотын албан татвар, түүнчлэн нийслэлийг хөгжүүлэх сантай байж болохоор, сангийн хөрөнгийн эх үүсвэр болон зарцуулах үйл ажиллагааны талаар тусгалаа.

Харин нарийвчилсан харилцааг Өрийн удирдлагын тухай, холбогдох татварын болон бусад хууль тогтоомжоор зохицуулахаар дагах хуулийн төсөл боловсруулсан болно.

Түүнчлэн нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой ажил, үйлчилгээг нийслэлийн өмчит болон нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдээр гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлдэг байх зохицуулалтыг тусгалаа.

Мөн нийслэлд хөрөнгө оруулах боломжийг нэмэгдүүлэх үүднээс нийслэл дэх хөрөнгө оруулалтыг тусгайлан дэмжих зохицуулалтыг нарийвчлан тусгалаа.

**Дөрөвдүгээр бүлэгт** нийслэлийн удирдлагын тогтолцоо, бүрэн эрх, ажлын уялдааны талаар тусгалаа.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн бүрэн эрхийг тодорхой болгон тусгаж, хотын аж ахуйн чиглэлээрх зарим бүрэн эрхийг хотын Ерөнхий менежерт шилжүүлэн хэрэгжүүлж болох талаар тусгав. Ийнхүү шилжүүлсэн нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй юм.

**Тавдугаар бүлэгт** нийслэлээс бусад этгээдтэй харилцах харилцааны талаар тусгасан бөгөөд нийслэл хотын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд төрийн дээд, төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн бусад нэгж, улсын зэрэглэлтэй хот, дүүргийн удирдлага, иргэн, аж ахуйн нэгжтэй нийслэлийн удирдлагын зүгээс харилцах харилцааг тодорхой тусгав.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд “аймаг, нийслэлийн Засаг дарга нь нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар санал, шийдвэрийн төсөл боловсруулж тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх, эс дэмжвэл саналаа Ерөнхий сайдад уламжлах;”-аар заасан.

Харин нийслэл нь хот болохын хувьд нийслэлийн Засаг дарга нь тусгай чиг үүргийг хэрэгжүүлдэг онцлог субъект болох юм. Иймд тусгай чиг үүрэгтэй холбоотой

асуудлаар хуулийн төсөл санаачлахаас бусад асуудлаар Засгийн газрын шийдвэрийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулдаг байхаар тусгалаа.

Төрийн захиргааны төв байгууллагаас нийслэлтэй хамтран ажиллах, нийслэлийн оршин суугчийн нийтлэг эрх ашигт хамаарах асуудлаарх бодлого, шийдвэрийн төсөлд нийслэлийн саналыг авсан байх шаардлагыг тусгалаа.

Түүнчлэн нийслэл хотын оршин суугчийн эрх, үүргийг хуульчилж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, орчноо тохижуулах, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг засаж сайжруулах, орчны аюулгүй байдлыг хангах, замын түгжрэл, хог хаягдал, орчны бохирдол, тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэх зэрэг нийслэл хотыг хөгжүүлэх үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулсан иргэн, хуулийн этгээдийг урамшуулах зохицуулалтыг бий болголоо.

**Зургаадугаар бүлэгт** Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулах, хөгжлийг дэмжих, иргэдийн таатай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, нийслэл хотод болон иргэн аж ахуйн нэгж байгууллагад эдийн засгийн хувьд эерэг нөлөө үзүүлэх зорилгоор нийслэл хотын дагуул хот болон эдийн засгийн тусгай бүс байгуулах эрх зүйн орчинг бүрдүүллээ.

Нийслэл хотын дагуул хот нь эдэлбэр газартай, хүн ам, эдийн засаг, дэд бүтэц, тээвэр, логистикийн нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, газар зүйн байрлал болон нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэхэд стратегийн ач холбогдолтой, дэд бүтэц бүхий төвлөрсөн суурин газар байхаар тодорхойлов.

Түүнчлэн дагуул хотыг байгуулах, түүний чиг үүрэг, удирдлага, зохион байгуулалтын талаар нарийвчлан тусгасан. Дагуул хотыг засаг захиргааны бусад нэгжийн нутаг дэвсгэрт дамнан байгуулж болох бөгөөд дагуул хотыг Улсын Их Хурлаас байгуулахаар тусгалаа.

Мөн энэ бүлэгт дагуул хот дахь эдийн засгийн тусгай бүсийн талаарх зохицуулалтыг шинээр бий болголоо.

Олон улсын туршлагаас авч үзвэл улс орнууд тодорхой чиглэл, байршилд чөлөөт бүсийг байгуулсан байх бөгөөд тухайлбал, Москва хотод инноваци, мэдээлэл технологи, аялал жуулчлал, үйлдвэрлэл технологийн чиглэлээр, Бээжин хотод технологийн шинэчлэл, өндөр зэрэглэлийн аж үйлдвэрийн чиглэлээр чөлөөт бүсийг тус тус байгуулж, ингэхдээ үйл ажиллагаа явуулах газар нутгийн хэмжээг тодорхой зааж, Чөжү хотод аялал жуулчлалын чиглэлээр чөлөөт бүсийг байгуулсан байна.

Эдгээр орны туршлагаас жишиг болгон эдийн засгийн тусгай бүсийг мэдээлэл технологи, инновацийн, аялал жуулчлал, соёл амралтын, хөнгөн үйлдвэрлэл, агаарын хөлгийн завсар үйлчилгээ, угсралтын, хүлэмжийн аж ахуйн чиглэлээр дагнан, эсхүл хослуулан байгуулж болохоор хуулийн төсөд тодорхой тусгалаа.

Эдийн засгийн тусгай бүсийг байгуулах болон тусгай бүс байгуулах газар нутгийн хэмжээ, байршлыг тогтоох асуудлыг Засгийн газар шийдвэрлэхээр тусгав.

Түүнчлэн нийслэлд байх тусгай бүсийн тоог 5-аас илүүгүй байхаар тусгасан бөгөөд тусгай бүсэд хуульд заасан чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжид татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгалаа. Харин тусгай бүсэд үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгжид үзүүлэх татварын болон татварын бус дэмжлэг нь согтууруулах ундаа болон тамхины үйлдвэрлэлд хамаарахгүй байхаар тусгалаа.

Тусгай бүсийн Захирагч нь Дагуул хотын захирагч байх бөгөөд түүнийг нээлттэй сонгон шалгаруулалт, нээлттэй сонсголын үндсэн дээр нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч томилохоор тусгав.

**Долоодугаар бүлэгт** нийслэлийн үйл ажиллагаа, удирдлагаас гаргаж буй шийдвэр болон төсөв санхүү нээлттэй, ил тод байх, нийслэлийн гадаад хамтын ажиллагаа, нийслэл хотын өдөр, нийслэлийн шагналын талаар болон хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацааны талаар тусгалаа.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Хот байгуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Улсын Их Хурлын 2020 оны “Хот байгуулах тухай” 55 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай зэрэг хууль тогтоомжид холбогдох өөрчлөлтийг оруулах төслийг боловсруулсан.

Тухайлбал, Хот байгуулалтын тухай хуульд Улаанбаатар хотын ерөнхий архитекторыг нээлттэй сонгон шалгаруулалт, нээлттэй сонсголын үндсэн дээр нийслэлийн Засаг даргаас томилохоор, Өрийн удирдлагын тухай хуульд нийслэл үнэт цаас гаргах болон үнэт цаас гаргах зориулалтыг тусгалаа.

Мөн ногоон хөгжлийн бодлого, зорилтыг дэмжихтэй холбогдуулан Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлд нийслэл хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэн, хуулийн этгээдийг дэмжиж, урамшуулах зохицуулалтыг тусгав.

Хуулийн төсөлд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах судалгаа, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ болон зардлын тооцоог хийсэн болно.

Түүнчлэн хуулийн төсөлд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдын дунд нийт 15 удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хуулийн төсөлд иргэн, хуулийн этгээдийн саналыг авахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан ёсны цахим хуудсанд байршуулж, олон нийтээр хэлэлцүүлж, холбогдох саналыг тусгаж ажиллаа.

-----oOo-----